

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/99/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом хот  
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Р.Аюуш

Утас: 70453721, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ТҮРГЭН СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ С.БАТСҮХ ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

додд. олд. дд № УВА-2022/99/НА-СТА-ТУУС  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200286

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>90,306,723.50</u></b>	<b><u>94,638,834.70</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	90,306,723.50	94,638,834.70
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	632,320.00	1,028,115.00
35130	Эм боох материал	632,320.00	1,028,115.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	89,674,403.50	93,610,719.70
35410	Бичиг хэргийн материал	1,019,711.00	1,618,157.48
35420	Аж ахуйн материал	83,263,697.00	86,330,034.32
35440	Түлш, шатах тослох материал	5,200,000.00	5,550,000.00
35460	Хүнсний материал	190,995.50	112,527.90
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,950,696,579.92</u></b>	<b><u>3,839,479,711.69</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,950,696,579.92	3,839,479,711.69
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,901,174,079.92	3,790,032,211.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,874,463,866.00	3,860,400,745.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-130,387,066.30	-213,479,157.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,499,999.96	-4,999,999.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	171,206,581.00	184,206,581.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-121,063,279.09	-136,195,058.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	111,051,489.72	111,051,489.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,871,370.95	-44,938,944.33
39217	Ном	17,273,859.50	18,986,555.70
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	49,522,500.00	49,447,500.00
39301	Программ хангамж	1,040,000.00	1,040,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-827,500.00	-902,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	49,310,000.00	49,310,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,041,003,303.42</u></b>	<b><u>3,934,118,546.39</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,041,003,303.42</u></b>	<b><u>3,934,118,546.39</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,041,003,303.42	3,934,118,546.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	847,304,547.50	847,304,547.50
51101	Өмч: - төрийн	847,304,547.50	847,304,547.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,718,601,125.44	2,672,267,256.41
51210	Өмнөх үеийн үр дүн	2,718,601,125.44	2,779,152,013.44
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-106,884,757.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	475,097,630.48	414,546,742.48
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>4,041,003,303.42</u></b>	<b><u>3,934,118,546.39</u></b>



2.2. АУДИТ ХИЙСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>790,963,752.00</b>	<b>810,122,292.40</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>29,630,452.00</b>	<b>45,690,754.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	29,630,452.00	45,690,754.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,630,452.00	45,690,754.40
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	29,630,452.00	45,690,754.40
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>156,333,000.00</b>	<b>185,582,038.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	605,000,300.00	578,849,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,610,000.00	4,756,438.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,756,438.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,610,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	145,723,000.00	180,825,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	145,723,000.00	180,825,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>878,987,487.63</b>	<b>861,646,237.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>878,987,487.63</b>	<b>861,646,237.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	819,639,986.39	812,200,791.74
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	463,484,163.00	450,139,560.00
210101	Үндсэн цалин	311,289,439.00	297,483,705.00
210102	Нэмэгдэл	101,302,835.00	108,594,291.00
210104	Урамшуулал	42,850,343.00	34,332,549.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,041,546.00	9,729,015.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,219,742.76	60,256,498.19
210201	Тэтгэврийн даатгал	40,949,265.52	41,955,954.37
210202	Тэтгэмжийн даатгал	4,817,319.06	4,667,207.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,854,135.65	3,653,105.78
210204	Ажилгүйдлийн даатгал	963,683.41	907,293.95
210205	Эрүүл мэндийн даатгал	9,635,339.12	9,072,936.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	140,458,563.00	155,572,504.04
210301	Гэрэл, цахилгаан	2,595,542.00	3,707,027.04
210302	Түлш, халаалт	137,792,221.00	151,651,477.00
210303	Цэвэр, бохир ус	70,800.00	214,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,511,185.00	7,216,790.00
210401	Бичиг хэрэг	2,220,400.00	1,875,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,207,030.00	2,354,190.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	185,500.00	450,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	332,500.00	747,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,206,100.00	1,789,900.00
210408	Бараа материал акталсны зардал	13,359,655.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	16,551,173.40	17,112,574.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	402,325.00	1,162,007.00
210502	Хоол, хүнс	15,908,748.40	15,950,567.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	240,100.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	3,525,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	3,525,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	934,000.00	462,000.00

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	934,000.00	462,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,418,900.00</b>	<b>2,442,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,108,900.00	590,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	403,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	1,449,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>116,062,259.23</b>	<b>115,473,464.91</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	499,750.00	1,091,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	115,562,509.23	114,382,464.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,347,501.24</b>	<b>49,445,445.77</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,981,200.00</b>	<b>13,836,000.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,207,200.00	11,772,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	774,000.00	2,063,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>47,826,864.24</b>	<b>14,206,349.81</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,826,864.24	14,206,349.81
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,539,437.00</b>	<b>21,403,095.96</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,539,437.00	21,403,095.96
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-88,023,735.63</b>	<b>-51,523,945.11</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>55,360,811.92</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	55,360,811.92
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-55,360,811.92</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-88,023,735.63</b>	<b>106,884,757.03</b>

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>765,058,300.00</b>	<b>764,431,538.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>765,058,300.00</b>	<b>764,431,538.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	605,000,300.00	578,849,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>14,335,000.00</b>	<b>4,756,438.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,725,000.00	4,756,438.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,610,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>145,723,000.00</b>	<b>180,825,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	145,723,000.00	180,825,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>765,058,300.00</b>	<b>751,431,538.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>765,058,300.00</b>	<b>751,431,538.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>705,710,798.76</b>	<b>701,986,092.23</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>463,484,163.00</b>	<b>450,139,560.00</b>
210101	Үндсэн цалин	311,289,439.00	297,483,705.00
210102	Нэмэгдэл	101,302,835.00	108,594,291.00
210104	Урамшуулал	42,850,340.00	34,332,549.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,041,549.00	9,729,015.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60,219,742.76</b>	<b>60,256,498.19</b>
210201	Тэтгэврийн даатгал	40,949,265.52	41,955,954.37
210202	Тэтгэмжийн даатгал	4,817,319.06	4,667,207.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,854,135.65	3,653,105.78
210204	Ажилгүйдлийн даатгал	963,683.41	907,293.95
210205	Эрүүл мэндийн даатгал	9,635,339.12	9,072,936.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>141,183,563.00</b>	<b>155,922,504.04</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,595,542.00	3,707,027.04
210302	Түлш, халаалт	138,517,221.00	152,001,477.00
210303	Цэвэр, бохир ус	70,800.00	214,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,026,680.00</b>	<b>8,688,830.00</b>
210401	Бичиг хэрэг	197,700.00	296,238.00
210402	Тээвэр, шатахуун	2,361,180.00	2,354,190.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	185,500.00	450,000.00
210404	Ном, хэвлэл	169,500.00	1,025,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,359,800.00	2,530,402.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	753,000.00	2,033,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>15,526,000.00</b>	<b>17,286,100.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	361,000.00	361,000.00
210502	Хоол, хүнс	14,112,000.00	15,872,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,053,000.00	1,053,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,110,000.00</b>	<b>3,500,000.00</b>

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	3,010,000.00	00.00
210602	Тавилга	9,100,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	3,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>934,000.00</b>	<b>462,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	934,000.00	462,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,868,900.00</b>	<b>2,442,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,108,900.00	590,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	403,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	1,449,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,357,750.00</b>	<b>3,288,200.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,357,750.00	3,288,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,347,501.24</b>	<b>49,445,445.77</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,981,200.00</b>	<b>13,836,000.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,207,200.00	11,772,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	774,000.00	2,063,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>47,826,864.24</b>	<b>14,206,349.81</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,826,864.24	14,206,349.81
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,539,437.00</b>	<b>21,403,095.96</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,539,437.00	21,403,095.96
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>13,000,000.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>13,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>13,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>13,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	13,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-13,000,000.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>



**2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	797,994,547.50	122,990,468.00	-182,257,627.67	00.00	738,727,387.83
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>797,994,547.50</b>	<b>122,990,468.00</b>	<b>-182,257,627.67</b>	<b>00.00</b>	738,727,387.83
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,950,575.21	00.00	-2,950,575.21
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>847,304,547.50</b>	<b>475,097,630.48</b>	<b>2,718,601,125.44</b>	<b>00.00</b>	4,041,003,303.42
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>847,304,547.50</b>	<b>475,097,630.48</b>	<b>2,718,601,125.44</b>	<b>00.00</b>	4,041,003,303.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	60,550,888.00	00.00	60,550,888.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>847,304,547.50</b>	<b>475,097,630.48</b>	<b>2,779,152,013.44</b>	<b>00.00</b>	4,101,554,191.42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-60,550,888.00	00.00	00.00	-60,550,888.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-106,884,757.03	00.00	-106,884,757.03
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>847,304,547.50</b>	<b>414,546,742.48</b>	<b>2,672,267,256.41</b>	<b>00.00</b>	3,934,118,546.39

## 2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	759,675,100.00	724,065,654.23	35,609,445.77	95.30%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	759,675,100.00	724,065,654.23	35,609,445.77	95.30%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	744,178,000.00	711,519,654.23	32,658,345.77	95.60%
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	452,813,700.00	450,139,560.00	2,674,140.00	99.40%
210101	Үндсэн цалин	303,872,500.00	297,483,705.00	6,388,795.00	97.90%
210102	Нэмэгдэл	109,049,900.00	108,594,291.00	455,609.00	99.60%
210104	Урамшуулал	29,811,300.00	34,332,549.00	-4,521,249.00	115.20%
210105	Гэрээт ажлын хөлс	10,080,000.00	9,729,015.00	350,985.00	96.50%
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	61,129,900.00	60,256,498.19	873,401.81	98.60%
210201	Тэтгэврийн даатгал	43,017,400.00	41,955,954.37	1,061,445.63	97.50%
210202	Тэтгэмжийн даатгал	4,528,200.00	4,667,207.61	-139,007.61	103.10%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,622,200.00	3,653,105.78	-30,905.78	100.90%
210204	Ажилгүйдлийн даатгал	905,900.00	907,293.95	-1,393.95	100.20%
210205	Эрүүл мэндийн даатгал	9,056,200.00	9,072,936.48	-16,736.48	100.20%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	177,325,600.00	155,922,504.04	21,403,095.96	87.90%
210301	Гэрэл, цахилгаан	9,300,000.00	3,707,027.04	5,592,972.96	39.90%
210302	Түлш, халаалт	167,365,600.00	152,001,477.00	15,364,123.00	90.80%
210303	Цэвэр, бохир ус	660,000.00	214,000.00	446,000.00	32.40%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,990,000.00	7,988,392.00	1,608.00	100.00%
210401	Бичиг хэрэг	397,700.00	189,800.00	207,900.00	47.70%
210402	Тээвэр, шатахуун	2,111,200.00	2,110,190.00	1,010.00	100.00%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	185,500.00	450,000.00	-264,500.00	242.60%
210404	Ном, хэвлэл	1,265,800.00	1,025,000.00	240,800.00	81.00%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,720,000.00	2,180,402.00	539,598.00	80.20%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,309,800.00	2,033,000.00	-723,200.00	155.20%
2105	<b>Нормативт зардал</b>	24,525,600.00	17,286,100.00	7,239,500.00	70.50%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	361,000.00	361,000.00	0.00	100.00%
210502	Хоол, хүнс	23,111,600.00	15,872,100.00	7,239,500.00	68.70%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,053,000.00	1,053,000.00	0.00	100.00%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,500,000.00	16,500,000.00	0.00	100.00%
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	13,000,000.00	0.00	100.00%

**Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210604	Урсгал засвар	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.00%
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	563,800.00	462,000.00	101,800.00	81.90%
210702	Дотоод албан томилолт	563,800.00	462,000.00	101,800.00	81.90%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,503,200.00	1,138,400.00	364,800.00	75.70%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	310,200.00	189,800.00	62.00%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00	0.00	100.00%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	425,000.00	175,000.00	70.80%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1826200.00	1826200.00	0.00	100.00%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,826,200.00	1,826,200.00	0.00	100.00%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	15497100.00	12546000.00	2,951,100.00	81.00%
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	15,497,100.00	12,546,000.00	2,951,100.00	81.00%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,723,100.00	11,772,600.00	2,950,500.00	80.00%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	774,000.00	773,400.00	600.00	99.90%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	759,675,100.00	724,065,654.23	35,609,445.77	95.30%
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	578,849,500.00	564,643,150.19	14,206,349.81	97.50%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	578,849,500.00	564,643,150.19	14,206,349.81	97.50%
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	180,825,600.00	159,422,504.04	21,403,095.96	88.20%
132001	Орон нутгийн төсвөөс	180,825,600.00	159,422,504.04	21,403,095.96	88.20%
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	42.00	42.00	0.00	100.00%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	27.00	27.00	0.00	
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	0.00	
620004	Гэрээт ажилтан	02.00	02.00	0.00	

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>4,756,438.00</b>	<b>-4756438.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>4,756,438.00</b>	<b>-4756438.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		3,466,438.00	-3466438.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		700,438.00	-700438.00
210401	Бичиг хэрэг		106,438.00	-106438.00
210402	Тээвэр, шатахуун		244,000.00	-244000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		350,000.00	-350000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		1,304,000.00	-1304000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		280,000.00	-280000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,024,000.00	-1024000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	1462000.00	-1462000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,462,000.00	-1462000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	1290000.00	-1290000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		1,290,000.00	-1290000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,290,000.00	-1290000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>00.00</b>	<b>0.00</b>
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	4756438.00	-4756438.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		4,756,438.00	-4756438.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,756,438.00	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь энэ хичээлийн жилд хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэх, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгын хүрээнд 8 зорилт тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн талаар хяналт мониторинг хийсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 7,031.9 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 861,646.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,616.5 мянган төгрөгийн 80 хувиар буюу 6,893.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 106,884.7 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Бараа материал	90,306.7	94,638.8	4,332.1
Үндсэн хөрөнгө	3,950,696.5	3,839,479.7	-111,216.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,041,003.3</b>	<b>3,934,118.5</b>	<b>-106,884.8</b>
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,041,003.3	3,934,118.5	-106,884.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,041,003.3</b>	<b>3,934,118.5</b>	<b>-106,884.8</b>



Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 94,638.8 мянган төгрөг болж 4,332.1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, бичиг хэрэг, эм боох материал байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,839,479.7 мянган төгрөг болж 111,216.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал 117,056.5 мянган төгрөг, ашиглалтын хугацаа дууссан 60,550.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан, 46,487.7 мянган төгрөгийн барилга, 687.7 мянган төгрөгийн номыг балансаас балансад шилжүүлэн авч, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 14,025.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,934,118.5 мянган төгрөг болж 106,884.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн хасагдсанаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 17,341.2 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна. Энэ нь үндсэн хөрөнгө данс буурсан, бараа материалын данс өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 13,626.8 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 973,095.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг ирүүлсэн саналаас 245,465.3 мянган төгрөгөөр бууруулж 727,629.8 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотгол хийгдэж 32,045.3 мянган төгрөгөөр өсгөн 759,675.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 759,675.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 759,675.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс 759,675.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 724,065.6 мянган төгрөгийг зарцуулж 35,609.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 724,065.6 мянган төгрөг буюу 95.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

20

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчаас 4,756.4 мянган төгрөгийн орлого орсныг зарцуулалтын эрх нээлгэн зориулалтын дагуу зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 133, хугацаа хоцорсон 16, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 392.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.2 Төлбөрийн акт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх хэсэгт “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасныг зөрчин сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчид 2, 4-р улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 392,917 төгрөг тооцож олгосон алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Түргэн сумын Ерөнхий боловсролын сургууль	1	392.9			1	392.9				
<b>ДҮН</b>		1	392.9			1	392.9				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/Р.АЮУШ/

2022 оны 02 сарын 24-ний өдөр